


鑄造の安全衛生

Зурагт номоор ойлгох

Цутгалтын аюулгүй байдал, эрүүл ахуй



Энэхүү дүрс бичлэгийн материалыг цутгалтын ажил хийдэг бизнесийн байгууллагад ажилладаг хүмүүст аюулгүй байдал, эрүүл ахуйн үндсийг сурах зорилгоор бүтээсэн болно.



Өнөөдөр цутгамалын ажлын аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар сурцгаая.



Өндөр температуртай эд зүйлтэй харьцах, хүнд материал хэрэглэх, цаашлаад машин техник ажиллуулах учраас аюулгүй байдалдаа анхаарахгүй бол болохгүй.

Тиймээ.



Ямар ажил хийдэг юм бол.

Юунаас болгоомжлох хэрэгтэй вэ?



Эхлээд хөдөлмөрийн осол гарч байгаа нөхцөл байдлыг авч үзье!

Тэгье

Хөдөлмөрийн ослын гол шалтгааныг авч үзье.




Цутгамалын ажилд хүний амь нас эрсдсэн ослын тохиолдол

1	Хавчуулагдах · орооцолдох	31 %
2	Халуун объектой харьцах	13 %
3	Өндрөөс ойчих - Унах	11 %
4	Өнхөрч унах	10 %
5	Болгоомжгүй үйлдэл-Хүчлэх	9 %

Лавлагаа: Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн яам
 “2019 онд мэргэжлээс шалтгаалсан осол, үйлдвэрлэл, ослын мэдээлэл”
 (Цутгах үйлдвэрлэл болон төмрийн бус цутгамал үйлдвэрлэлийн дүнг нэгтгэв.)

* Цутгахтай холбоотой олон үйл ажиллагаа нь тоос үүсгэдэг тул тоос шорооноос үүдэлтэй бэрхшээл гарах вий гэсэн болгоомжлол байдаг.



Зөвхөн ослоос урьдчилан сэргийлэх төдийгүй тоос шорооны бэрхшээлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай.



* Аюулгүй байдлыг хангах дүрмүүд нь зөвхөн хууль тогтоомж, дүрэм журмаас гадна урьд өмнө гарсан олон алдаа, осол дээр үндэслэгдэн хийгдсэн байдаг.



Крантай холбоотой бусад олон осол аваар гарч байна. Дээш өргөгдсөн цутгуурийн хэвэнд мөргүүлэх, хана хооронд хавчуулагдах гэх мэт том осол гарах тохиолдол байдаг.



Цутгамалын хэв болон цутгамал дээрээс унахаас болгоомжилгоорой. Зарим нь хэдэн зуун кг жинтэй байдаг тул толгойгоо цохиулах, хүнд юманд дарагдах гэх мэтээр амь насаа алдах ч тохиолдол байдаг.

Аюул осол үргэлж хажууханд байдаг байх нь ээ.



Тийм л учраас дүрэм журмыг ягштал баримтлах нь чухал юм.



Мөн өөрийгөө хамгаалахын тулд хамгаалах хувцас хэрэгслийг өмсөх нь чухал. Олон төрөл байх учир зориулалтын дагуу сонгох хэрэгтэй.




Жишээлбэл тоос шорооноос хамгаалахын тулд маск зүүх нь үр дүнтэй байдаг.

Ерөнхийдөө юуг илүүтэйгээр анхаарах ёстой вэ?



4S гэж мэдэх үү?

4S бол Seiri (Зохион байгуулах), Seiton (Цэмцгэр), Seiso (Цэвэрлэгээ), Seiketsu (Цэвэр байдал). Энэ нь аюулгүй байдлын үндэс суурь юм.



За тэгвэл,





Бодит байдал дээр


харцгаая



Тохиолдол 1 Түлэгдэлт








Эмхтгэл: Тохиолдол 1

1 Ажлын байран дээр зохих хамгаалалтын хэрэгслийг хэрэглэх.



2 Органик уусгагч амархан асдаг тул маш болгоомжтой байх!




TIPS Цутгамалд хүрэхдээ арьсан бээлий өмсье!



Тохиолдол 2

Өнгөлөгч машинаас болсон гэмтэл






Хурдхан дараагийн ажлаа эхлүүлье

Ямартай ч нэлээд өвдөж байгаа даа.



Металл нунтаг эргэн тойронд үсрээд харахад хэцүү байгааг мэдэхгүй байсан юм байхдаа.



Юу вэ? Цутгамал хөдлөөд байх чинь.

Сонин юм даа



Ёооё



Өвдөж байна! Хөлөн дээр цутгамал уначихлаа.



Өө. Цутгамалаа бэхлэгчинд тогтоохоо мартчихсан байна ш дээ.

Хөлний хамгаалах хэрэгсэл өмсдөг байж.



Бага зэрэг өвдөж байгаа боловч, ямар ч байсан гайгүй байх шиг байна.



2 цагийн дараа

Цутгамал унасан хэсэг бага багаар өвдөлт нэмэгдэж бага зэрэг халуу оргих мэдрэмж төрж байна.



Яачихсан юм бол оо?



Хөөх, маш их хавдсан байна.

Хянагчаа!
Хөлөө гэмтээчихлээ.



Яс цуурсан байна уу?

Хэтэрхий оройтож мэдэгдлээ. "Бэртсэн ч байж магадгүй" гэж бодсон даруйдаа шууд мэдэгдэх хэрэгтэй шүү дээ.


Бэхлэгээг ч, хамгаалах хэрэгслийг ч мөн заавал хэрэглэх ёстой.

Гэмтэх юм бол өөрөө л хэцүү байдалд орох болно. Энэ удаа амрангаа сайн эдгээгээрэй.

Тэр тогтоосон журмыг мөрдөх нь чухал гэдгийн бодитоор ойлголоо.

ЭМХТГЭЛ: Тохиолдол 2

1 Өнгөлөх ажилд анхааралтай байцгаая!



Эргэлдэж буй хэвээр нь ширээн дээр тавих юм бол унаж хөлөө гэмтээнэ. Өнгөлөж байхад нунтаг үсрэх магадлалтай тул нунтаг чулуу нь таны биеийг цохиж, хүнд гэмтэл учруулж болзошгүй тул болгоомжтой байгаарай.


Өнгөлөгч чулууг солих болон солих үеийн турших ажлыг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль тогтоомжийн дагуу аюулгүй байдал эрүүл ахуйн тусгай боловсрол эзэмшсэн ажилтан гүйцэтгэхгүй бол болохгүй.

2 Тогтоосон дараалал журмын дагуу ажиллая!



Юу вэ? Цутгамал хөдлөөд байх чинь.

Сонин юм даа



Ёооё

Ажлаа үргэлжлүүлэхдээ процедурыг зөв хийж, аюул осол байгаа эсэхийг дахин нэг шалгаарай.

TIPS

Өнгөлөгчтэй ажиллах болон ойртох үедээ хамгаалалтын нүдний шил зүүе!








Өнгөлгөөний ажил хийж байх үед үсэрч буй металл нунтаг нь оч болон сайн харагддаг боловч



30 см-ээс хол үсэрвэл хөрөөд хар өнгөтэй болж сайн харагддаггүй.




Хажуугаар нь ойрхон өнгөрч байгаа хүн ч гэсэн хамгаалалтын шил зүүх хэрэгтэй.

Тохиолдол 3 Туузан дамжуулагчид хавчуулагдах, орооцолдох








Туслаарай!

Зүгээр үү?



Гараа хугалаад
Том осол боллоо.

Татагдаж
орох маш аймар.
Амь насаа ч алдах
тохиолдол бий.
Аюултай байлаа.



Харж байна уу!
Дуу гаргаж дохио өгөөгүй,
таг авч янзалсанаа мартаад,
урагдсан хувцсаа тэр хэвээр нь орхиж,
машин техник, нарийн багаж
төхөөрөмжинд оролцоод,

иймэрхүү жижиг
сажиг олон дүрэм журмуудыг
зөрчсөнөөс ийм том осол
болж байна ш дээ.

Тийм ээ

Тэд "Үүнээс хойш маш
болгоомжтой ажиллацгаая"
гэж амаллаа.

ЭМХТГЭЛ: Тохиолдол 3

1 Дахин эхлүүлэхээс өмнө дахин нэг удаа шалгах!




Хэрэв таглаа болон аюулгүй байдлын төхөөрөмжийг шалгахаар авсан тохиолдолд

1. Заавал буцааж таглах, буцаах.
2. Зөрсөн хазайсан эсэхийг шалгах.
3. Эргэн тойронд чинь хариу дугараагүй хүн байна уу гэж шалгасны дараагаар цахилгаана асаах.

Хэвийн бус тохиолдолд олон хүн үүнийг зохицуулах ёстой!
Хяналтын ажилтанд мэдээлэх!

2 Машин техник ажиллаж байхад нарийн багаж төхөөрөмжинд хүрч болохгүй!



Ажлын хувцас болон багаж хэрэгсэл татагдан хавчуулагдахаас сэргийлэх.

Жишээ нь:

Ажлын хувцасны ханцуй
Бээлий Хүрз Урт үс
Оосор бүс уяа гэх мэт

TIPS

4S-ийг сайтар хэрэгжүүлэх нь аюулгүй байдлын үндэс юм!

Seiri (Зохион байгуулалт)

- Юуг ашиглах, засах, хаях зүйлээ ялгаж салга.
- Шаардлагагүй зүйлийг хая.

Seiton (Цэгцлэх)

- Багаж хэрэгслийг зориулалтын байранд тавь.
- Явах зам дээр ямар нэгэн зүйл тавьж болохгүй.

Seiso (Цэвэрлэгээ)


- Ажлын байр бохирдвол шууд цэвэрлэ.
- Шалан дээр юм бүү хая.

Seiketsu (Цэвэр байдал)

- Хувцаслалтаа анхаарах
- Ажлын хувцасаа бохирдсон, урагдсан хэвээр орхиж болохгүй.
- Багаж хэрэгсэл, хамгаалалтын хэрэгслийг арчлах.



Аюул гайхалтай ойрхон байгааг мэдрэв үү?



Тэмдэгтүүдийн тэнэг хэсэг нь хэн нэгэнтэй төстэй юм аа.

Айн? Ямар нэгэн юм хэлсэн үү?



Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн хувьд хувь хүн бүрийн ухамсар бөгөөд дүрмийг дагаж мөрдөх нь чухал юм.

Тэгсэн ч ахин Тэгээд харцгаая.



Хөдөлмөрийн осол бол бусдын асуудал биш бидэнд ойрхон байдаг асуудал юм.

Дүрэм журмаа баримтлах нь "өөрийгөө", "гэр бүл", "амьдрал"-аа хамгаалж байна гэж санаж яваарай.



Хэрэв ямар нэг зүйл болвол Өдөр бүрийн ажил дээрх харилцаа холбоо бас чухал юм.



За. Дүрэм журмаа баримтлаж өдөр бүр хичээцгээе.

Хамгаалах хэрэгслүүд

Хэрэгцээндээ нийцсэн хамгаалалтын хэрэгслийг ашиглаарай!



Хамгаалалтын малгай

Толгойг цохихоос хамгаалах зүйл.



Эрүүний оосорыг тохируулж, хөдлөхгүй байхаар чангах. Хэрэв та нэг удаа ч байсан цохиулбал түүнийгээ солиорой.

Хормогч


Халах зэргээс хамгаалах.



Аль болох урт зүүх.

Сүүдэрлэх шил

Хурц гэрлээс нүдийг хамгаалах.



Нүүрэнд яг таарсан байх

Хамгаалах шил

Үсэрч ирэх зүйлс болон тоос шороо, халуунаас нүдийг хамгаалах.




Аюултай эсвэл хортой бодисын төрлөөс хамаараад тохирохыг хэрэглэнэ.

Амьсгалах амгаалах хэрэгсэл


Тоосжилтын маск

Тоос шороо нэвтрүүлэхгүй байлгах маск




Хийн баг

Хортой хийнээс хамгаалах маск



- Хортой бодисын төрөл, концентрацид тохирохыг ашиглах.
- Нүүрэнд сайн тулгаж зүүсэн эсэхийг шалгах (тохиромжтой байдлыг шалгах).
- Шүүлтүүр болон шингээгчийг солих.
- Нэг удаагийн маск бол ашиглалтын хугацааг мөрдөх.




Их хэмжээний тоосоор удаан хугацааны туршид амьсгалах нь уушгинд үрэвсэл үүсгэдэг.

Бээлий

Халуун болон хурц гэх мэт зүйлээс гарыг хамгаалах зүйл.

Материал нь хэрэгцээндээ тохирсон мөн ханцуй урт, таван хуруутай бээлийг ашиглах.



Бугуйн хавхаг

Очис зэрэг өндөр температурт хайлсан зүйлсээс хамгаалах.

Арьсыг ил гаргахгүй байх зориулалттай.



Аюулгүйн гутал

Хүнд зүйлээс хөлийг хамгаалах



Өөрт тохирсон хэмжээтэй гутал өмсөх. Хөлөн дээрх хамгаалах хэрэгслийг зүүх

Түрий

Очис зэрэг нэвтрэхгүй байхаар хийгдсэн

Сулархааргүй байхаар өмсөх.



Хамгаалах хэрэгсэл нь ажлын нөхцлөөс шалтгаалан тохирсныг сонгон, зөв ашиглахгүй бол ашигласны хэрэг гарахгүй.



Арга хэмжээ 1

Зөв өмсөж, зөв хэрэглээрэй!

Буруу зүүх болон цоорхой байгаа эсэхийг шалгах!



Арга хэмжээ 2

Биеийнхээ хэмжээнд тохирсон хамгаалалтын хэрэгслийг ашиглаарай!

Хэмжээ таарахгүй тохиолдолд шууд сольж авах.



Арга хэмжээ 3

Бохирдсон гэмтсэн хэвээр нь орхихгүй байх!



Бохирдлыг цэвэрлэх



Эвдэрсэн, цоорсон байвал солих хэрэгтэй.



Цэвэрхэн газар хадгалах.

Зурагт номоор ойлгох

Цутгалтын аюулгүй байдал, эрүүл ахуй

2021 оны 3-р сарын хэвлэл

Хэвлүүлсэн: Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн яам

Төлөвлөлт: Mizuho Information & Research Institute, Inc.

Хамтын ажиллагаа: Цутгалтын ажилтай холбоотой

аюулгүй ажиллагааны боловсролын материал

Үйлдвэрлэл: Sideranch Inc.



Энэ материалтай холбоотой холбоо барих
Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн яамны
Хөдөлмөрийн стандартын товчооны
Аюулгүй ажиллагааны хэлтэс,
Аюулгүй байдал, эрүүл ахуйн газар